



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 47

Эрдэнэт

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгөнд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Д.Батлут/-д, мөрдөж ажиллахыг Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 154 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

00100077